



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 10 өдөр

Дугаар А/14

Мөрөн сум

Газар эзэмших эрх дуусгавар болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.3, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1, заалт тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2023 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн А/331 дүгээр захирамжийн хавсралтын 7 дахь заалтаар газар эзэмшигч байгууллага “Хөвсгөл аймгийн гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар” (РД:4125444)-ын Мөрөн сум 8 дугаар баг 6712017944 нэгж талбарын дугаартай төрийн захиргааны байгууллагын зориулалтаар эзэмшүүлсэн 3104м² газрын газар эзэмшигч “Хөвсгөл аймгийн гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар” нь газар эзэмших гэрээгээ цуцлах тухай хүсэлт гаргасны дагуу газар эзэмших эрхийг нь дуусгавар болгож нийтийн эзэмшилд шилжүүлсүгэй.


2. Уг захирамжаар газар эзэмшиж байсан газар эзэмшигч хуулийн этгээд “Хөвсгөл аймгийн гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар” (РД:4125444)-ын 0000230602 дугаартай газар эзэмших эрхийн гэрчилгээ, аймгийн Засаг даргын 2023 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн А/331 дүгээр захирамжийн хавсралтын 7 дахь заалтыг тус тус хүчингүй болгож газар эзэмшигчийн мэдээллийн сангаас хасалт хийхийг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Б.Ганзориг)-д зөвшөөрсүгэй.

3. Аймгийн Засаг даргын захирамжийг эс зөвшөөрвөл захирамжийг мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор аймгийн Засаг даргад гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

4. Захиргааны актыг ажлын 5 хоногийн дотор эрх, ашиг сонирхол хөндөгдөж буй этгээдэд мэдэгдэж, баримтжуулсан захиргааны актыг хувийн хэрэгт бүрдүүлэлт хийж ажиллахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Б.Ганзориг)-д үүрэг болгосугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга (Р.Машбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ

Захирамж2024

6712010049